

БАТЛАВ

ДАРГА

А.НАНСАЛМАА

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛ,
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

**ВИДЕО КОНТЕНТ ХИЙХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/ *“Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх*-ын ажил
гэрээний нэр:

Тендер шалгаруулалт/
гэрээний дугаар: ***ОНТ-5.7/2019***

Чойбалсан хот
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019.08.14

Тендер шалгаруулалтын дугаар: *ОНТ-5.7/2019*

Дорнод аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **38,5** сая төгрөгний *“Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх*-ын ажил тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь *цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.*

Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг *2019 оны 08-р сарын 21-ний өдрийн 08 цаг 00 минутаас* өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг *2019 оны 08-р сарын 21-ний өдрийн 08 цаг 10 минутад* нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: *Эрхгүй*

Дотоодын давуу эрх тооцох эсэх: *Тооцохгүй.*

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Дорнод аймгийн Хэрлэн сумын 9 дугаар баг,
Боловсрол, соёл урлагийн газар
Утас: 99582454
Цахим систем: www.tender.gov.mn*

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 1.2. Тендерт оролцогч ажлын даалгаварт заасан үйлчилгээнд мэргэжлийн баг ажиллуулах бөгөөд дараах мэргэжилтнүүдийг заавал оролцуулна. Үүнд:
- *Найруулагч-1*
 - *Зураглаач-2*
 - *Эвлүүлэгч-1*
 - *Бусад мэргэжилтэн албан хаагч*
- Санал болгож буй багийн гишүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан байх бөгөөд бөгөөд тэдгээрийн мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбарыг үнийн саналын хамт ирүүлнэ.
- 1.3. Дараах үндсэн багаж, хэрэгсэлийг үйлчилгээ үзүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:
- *Суурин компьютер*
 - *Зөөврийн компьютер*
 - *Дүрс бичлэгийн камер*
- 2. Тендерийн иж бүрдэл**
- 2.1. Тендерт оролцогч нь *Мэргэжлийн студитэй хуулийн этгээд байна*. Тендерт оролцогч нь дараах зүйлийг тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:
- (1) *Үнийн санал;*
 - (2) *Үйл ажиллагааны хуваарь, хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлал;*
 - (3) *Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд санал болгож буй үнийн 20 хувиас багагүй дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх /гэрээ, акт хавсаргах/*
 - (4) *Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх,*
 - (5) *Шүүхийн тодорхойлолт,*
 - (6) *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт,*
 - (7) *Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт,*
 - (8) *Харилцагч банкны тодорхойлолт,*

Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.

Тухайн тендер нь дараах багцуудаас бүрдэнэ. Үүнд:

БАГЦ 3 Аялал эуулчлалын үйлчилгээг олон нийтэд хүргэх, видео контент хийх 7.5 сая

БАГЦ 4 Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө болон ИТХ-ын тогтоолоор батлагдсан байгалийн болон үүх соёлын үзэсгэлэнт газруудыг аялал жуудчлалын бүтээгдэхүүн болгон олон нийтэд хүргэх, видео контент хийх 15,0 сая

Нийт төсөвт өртөг 38,5

Оролцогч багц тус бүрт санал бэлтгэн ирүүлнэ.

- | | |
|---|---|
| 3. Тендерийн үнэ | <p>3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт үйлчилгээ хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үйл ажиллагааны хуваарьт үндэслэнэ.</p> <p>3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон үйл ажиллагааны хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| 4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | <p>4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш [30]¹ хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| 5. Алдагч залруулах | <p>5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:</p> <p>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</p> <p>(б) үйл ажиллагааны үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үйл ажиллагааны үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;</p> <p>(в) нэгж үнийг үйлчилгээний тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.</p> |

- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1. Гүйцэтгэгч үйлчилгээ үзүүлэх**
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан үйлчилгээг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 2. Төслийн менежерийн шийдвэр**
- 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
- 3. Үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр үйлчилгээ дууссан байх**
- 3.1. Гүйцэтгэгч үйлчилгээг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан үйл ажиллагааны хуваарь болон төслийн менежерийн баталсан тодотгосон үйл ажиллагааны хуваарийн дагуу хийж гүйцэтгэн, үйлчилгээ дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
- 4. Аюулгүй байдал**
- 4.1. Гүйцэтгэгч бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
- 4.2. Үйлчилгээ үзүүлэхэд байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь үйлчилгээтэй холбогдуулж байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
- 5. Зааварчилгаа**
- 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.
- 6. Маргааныг шийдвэрлэх**
- 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- 7. Үйл ажиллагааны хуваарь**
- 7.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хуваарийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
- 7.2. Үйл ажиллагааны хуваарийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь үйл ажиллагааны хуваарийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
- 8. Зөрчил, гологдол илрүүлэх**
- 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн үзүүлсэн үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа үйчилгээнд зөрчил, гологдол хайх, далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
- 9. Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үйл ажиллагааны хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарийн тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үйл ажиллагааны хуваарь нь үйл ажиллагааны хөтөлбөрт нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үйл ажиллагааны хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үйл ажиллагааны хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр үйлчилгээний арга барил, эсхүл үйл ажиллагааны хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үйл ажиллагааны хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үйл ажиллагааны хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хуулийг баримтална.

хэмжээгээр алданги³ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Үйлчилгээ дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь үйлчилгээ дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер үйчилгээ дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Гэрээг цуцлах** 17.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 17.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:
- (а) Үйл ажиллагааны хөтөлбөрт үйлчилгээ зогсоох тухай заагаагүй, түүнчлэн үйлчилгээ зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч үйлчилгээг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер үйлчилгээний явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
 - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

(е) гүйцэтгэгч үйчилгээний гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

17.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч үйчилгээг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**18. Гэрээг
цуцалсан
үед хийх
төлбөр**

18.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн үйлчилгээний болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй үйлчилгээний гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

18.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн үйлчилгээ болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, үйлчилгээний зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**19. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

19.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйлчилгээг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн үйлчилгээ болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн үйлчилгээний хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн беглэсэн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

- 2.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: *“Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх*”
- 2.1** Ажил нь *Дорнод аймгийн видео контентийн сан бүрдүүлэх* үзүүлнэ.
Ажлын талбай нь *Дорнод аймгийн Хэрлэн сумд* байрших ба ажлын даалгаварт зааснаар тодорхойлогдсон болно.
- 3.1** Төслийн менежер нь *Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар*
- 4.1** Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр *2019 оны 08 дугаар сарын 06-оос 09-р сарын 06-ны хооронд* багтаана.
- 7.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 13.1** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн *0,05 хувь* байна.
Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн *10 хувь* байна.
- 19.1** Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын *[хувь]*-иар тооцно.

Тав. АЖЛЫН ДААЛГАВАР

БАГЦ-3



Зорилго:

Аймгийн “Аялал жуулчлалыг дэмжих жил”-ийг тохиолдуулан, аймаг, орон нутгийнхаа түүх, өв соёл, онцлог, хөгжил дэвшлийг дотоод, гадаадын жуулчид, олон улс, үндэсний хэмжээнд сурталчилан таниулах зорилготой “Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх

Контентийн чиглэл:

Аялал жуулчлалын үйлчилгээг олон нийтэд хүргэх, видео контент хийх

Хийгдэх ажил, тавигдах шаардлага:

1. Буйр-Халхголын хил орчмын бүс 4-5 минут, Тосонхулстай хэрлэн голын бүс 4-5 минут, Монгол Дагуур хөх нуурын бүс 4-5 минут, Угтам-Яхь нуурын бүс 4-5 минут, Чойбалсан хот орчмын бүс 4-5 минутын тайлбартай дуу оруулга, дүрстэй нийт 5 контент байна.
2. Чойбалсан хотын 2 минут, Буйр нуур-Халхголын бүс нутгаар 2 минут, Дорнод аймгийг бүхлээр нь оруулсан 3 минутын тайлбаргүй, ая, дүрстэй 3 ширхэг контент байна.
3. Аялал жуулчлалыг дэмжих жилийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээг багтаасан 5 минутын танилцуулга, контентийг хийнэ.
4. Тендерт оролцогч нь контент тус бүрд зохиол бичиж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хамт ирүүлнэ.
5. Тендерт оролцогчийн зохиолд, захиалагчийн зүгээс нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүлээн авах боломжтой байх.
6. Зохиогчийн оюуны өмчийн эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хүндэтгэлтэй хандах
7. Бүтээл нь 4K форматтай, орчин цагийн техник тоног төхөөрөмж, телевизийн дамжуулалт, цацалтын шаардлагыг бүрэн хангасан байх
8. Бүтээлийн зүүн дээд буланд Дорнод аймгийн логог байршуулсан байх
9. Бүтээлийг англи, орос, хятад хэлээр тус бүр хадмал орчуулгатайгаар нэмж бэлтгэх
10. Бүтээлийн эхийг DVD болон эх файлаар, гэрээнд заасан хугацаанд багтаан, захиалагч талд хүлээлгэн өгөх

9. Урьд өмнө хийгдсэн уран бүтээл, нийтэд түгээгдсэн дүрсийг ашиглаагүй байх
10. Тендерт оролцогч нь өөрийн дүрс, бичлэгийн студи, тоног төхөөрөмжтэй байх
11. Ижил төрлийн 2-оос доошгүй ажил гүйцэтгэсэн туршлагатай, мэргэжлийн багтай байх бөгөөд тус бүтээлийг хавсаргасан байх

Нийт төсөв: 7.5 сая төгрөг

БАГЦ-4



Зорилго:

Аймгийн “Аялал жуулчлалыг дэмжих жил”-ийг тохиолдуулан, аймаг, орон нутгийнхаа түүх, өв соёл, онцлог, хөгжил дэвшлийг дотоод, гадаадын жуулчид, олон улс, үндэсний хэмжээнд сурталчилан таниулах зорилготой “Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх

Контентийн чиглэл:

Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан байгалийн болон түүх, соёлын үзэсгэлэнт газруудыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон олон нийтэд хүргэх, видео контент хийх

Хийгдэх ажил, тавигдах шаардлага:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-г сурталчлах зорилгоор аялал жуулчлалын 5 бүс нутгийн түүх, соёлын үзэсгэлэнт газруудыг багтаасан, аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, хэтийн зорилтыг агуулсан 15 минутын 2 төрлийн зохиомжит контентийн зохиолыг захиалагчийн өгсөн чиглэлийн дагуу бичиж ирүүлэх.
2. Захиалагчаар батлуулсан зохиолын дагуу 4К форматтай, орчин цагийн техник тоног төхөөрөмжийн дамжуулалт, цацалтын шаардлагыг бүрэн хангасан 15 минутын 2 төрлийн зохиомжит контент хийж, олон нийтэд хүргэх
3. Тендерт оролцогч нь контент гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг ирүүлнэ.
4. Тендерт оролцогчийн зохиолд, захиалагчийн зүгээс нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүлээн авах боломжтой байх.

5. Зохиогчийн оюуны өмчийн эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хүндэтгэлтэй хандах
6. Бүтээл нь 4K форматтай, орчин цагийн техник тоног төхөөрөмжийн дамжуулалт, цацалтын шаардлагыг бүрэн хангасан байх
7. Бүтээлийн зүүн дээд буланд Дорнод аймгийн логог байршуулсан байх
8. Бүтээлийг англи, орос, хятад хэлээр тус бүр хадмал орчуулгатайгаар нэмж бэлтгэх
9. Бүтээлийн эхийг DVD болон эх файлаар, гэрээнд заасан хугацаанд багтаан, захиалагч талд хүлээлгэн өгөх
10. Урьд өмнө хийгдсэн уран бүтээл, нийтэд түгээгдсэн дүрсийг ашиглаагүй байх
11. Тендерт оролцогч нь өөрийн дүрс, бичлэгийн студи, тоног төхөөрөмжтэй байх
12. Ижил төрлийн 2-оос доошгүй ажил гүйцэтгэсэн туршлагатай, мэргэжлийн багтай байх бөгөөд тус бүтээлийг хавсаргасан байх

Нийт төсөв: 15 сая төгрөг

Зургаа. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА А.НАНСАЛМАА ТАНАА

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

“Дорнод” видео контентийн сан бүрдүүлэх”-ын ажил

Дугаар №

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :
Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;
Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.
4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт;

Зураг;

Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь⁵;

Санхүүжилтийн хуваарь;

Ажил гүйцэтгэх хуваарь;

Бусад шаардлагатай баримт бичиг⁶.

⁵ Нэгж үнийн гэрээнд “үе шатны ажлын хуваарь” гэснийг “ажлын тоо хэмжээ” гэж солино.

⁶ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
4. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]